



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 11 сарын 17 өдөр

Дугаар 101

Улаанбаатар хот

┌ Нийслэлийн өмчид 6 барилга байгууламж
бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт Азийн хөгжлийн банкны зээлийн санхүүжилт болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, ашиглалтад орсон нийт 6,860,664,796.39 (зургаан тэрбум найман зуун жаран сая зургаан зуун жаран дөрвөн мянга долоон зуун ерэн зургаан төгрөг гучин есөн мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан Баянхошуу дэд төв 1 дүгээр хэсгийн ус, дулаан дамжуулах төвийн 6 барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийг нийслэлийн өмчид бүртгэн авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

1110100363

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 101 дүгээр тогтоолын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Бүртгэх байгууллага
1	Баянхошуу дэд төв 1 дүгээр хэсгийн ус дулаан дамжуулах төвийн 6 барилга, байгууламж, дулаан механикийн тоноглолууд	Сонгинохайрхан дүүргийн 8 дугаар хороо	2021	ком	4	4,608,619,130.16	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	“Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар” ОНӨААТҮГ
		Сонгинохайрхан дүүргийн 9 дүгээр хороо		ком	1	1,139,398,562.25		
		Сонгинохайрхан дүүргийн 28 дугаар хороо		ком	1	1,112,647,103.99		
НИЙТ ДҮН					6	6,860,664,796.39		